

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ 2023 ОНД  
ХЯНАЛТАД ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ  
ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА**

2023 оны 07 дүгээр сарын 05

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Монгол Улсын Хууль, УИХ, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврыг хэрэгжүүлэхээр хяналтад авсан шийдвэрийн заалтуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагуудыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөг тогтоох замаар цаашид хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд оршино.

**ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ тайлан мэдээлэл, түүнийг нотлож буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн бөгөөд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг орон нутагт чанартай, үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүний хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн удирдлагуудыг болоод Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрыг үнэн зөв мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар“БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ”-д заасан үнэлгээ хийх аргачлалын дагуу гүйцэтгэлээ.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтыг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнд явцын хяналт шинжилгээг тусгай удирдамж гарган аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23 газар, хэлтэс, агентлагт зохион байгуулан зөвлөн тусалж ажиллалаа.

Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцах хуудсаар цохолт хийж, харьяа хэлтсүүд хяналтандаа авахаас гадна төрийн байгууллагын цахим системд бүх төрийн албан хаагчдад нээлттэйгээр байршуулж хяналтад авахуулж байна.

## ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЯВЦ

Дундговь аймагт 2023 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /unelgee.gov.mn/-д байршуулсан МУ-ын хууль- 15, УИХ-ын тогтоол -4, УИХ-ын байнгын хорооны тогтоол- 12, Ерөнхийлөгчийн зарлиг -11, ҮАБЗ-ийн зөвлөмж-5, Засгийн Газрын тогтоол-20, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл-19, ЗГ-ын албан даалгавар 4-ийн нийт **90** заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс авч нэгтгэн, ирүүлсэн тайланд Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолоор баталсан БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ-ын 6.3-д заасан үнэлгээ өгөх аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт 90 заалтын биелэлт 90.49 хувьтай байна. Хэрэгжилтийг үнэлгээний үе шат тус бүрээр нь авч үзвэл:

- ❖ Бүрэн хэрэгжсэн 59 заалт нь нийт заалтын 65.5хувь
- ❖ Хэрэгжих шатандаа байгаа 19 заалт нь 21 хувь
- ❖ Хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн 3 заалт нь 3.3хувь
- ❖ Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй болон аймагт хамааралгүй заалтууд 9 заалт 10 хувийг эзэлж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг графикаар харуулбал:



Дундговь аймагт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт болон биелэлтийг Dundgovi.gov.mn сайт болон төрийн байгууллагын цахим программ болох erp.e-mongolia.mn программын файлын сан хэсэгт байршуулж, мөн мэдээллийн самбарт байршуулан мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн явцын хяналт шинжилгээгээр төрийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

### Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтын хэрэгжилтийн товчоо

Агуулга	Бүгд	Үүнээс								
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	51	4	2	4	5	3	13	18	42	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	90	15	4	12	11	5	20	19	4	
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн /100%/	59	7	2	11	10	2	11	13	3
	Хэрэгжих шатандаа 70%	19	3	1	0	1	3	6	4	1
	Хэрэгжилт хангалтгүй 30%	3	2	0	0	0	0	0	1	0
	Хэрэгжээгүй 0%	-	0	0	0	0	0	0	0	0
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	9	3	1	1	0	0	3	1	0
Хяналтнаас хасах санал	0	0	1	0	1	0	0	5		
<b>БИЕЛЭЛТИЙН ДҮН /Хувь/</b>	<b>90.74</b>	<b>80.83</b>	<b>90</b>	<b>100</b>	<b>97.27</b>	<b>82</b>	<b>89.41</b>	<b>89.44</b>	<b>90.49</b>	

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоолын хэрэгжилт 100 хувьтай буюу үр дүнтэй хэрэгжсэн байна МУ-ын хууль 80.83 хувийн хэрэгжилттэй буюу хамгийн бага хувьтай мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж 82 хувийн хэрэгжилттэй байна.

ЗГ-ын хуралдааны тэмдэглэл 5 заалт нэг удаагийн шинжтэй тул хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүнг тайлагнахаас гадна заалт бүрийг хяналтаас хасуулах санал оруулсан.

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй 2 заалт байна.**

Үүнд:

д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Шалтгаан
1	<b>2017.02.01. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/</b>	18.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	"Гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг чиг үүргийн байгууллагатай хамтран ажиллах хэлэлцүүлэг зохион байгуулж, санал солилцсон. Хамтарч ажиллах байгууллагаас төлөвлөгөөний саналыг авч нэгтгэн төлөвлөгөө боловсруулалтын шатандаа явагдаж байна. Бусад байгууллагатай хамтран хөтөлбөр боловсруулах шаардлагатай. ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ-г 2023 оны 07 сарын 04-ний өдрийн байдлаар шинэчилэн боловсруулж ажиллаж байна. "	Зохион байгуулалттай холбоотой гоор хэрэгжилт удааширсан.
2	2022_24. 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл	XIY.8.3. Хот, суурин газруудын хөгжлийн чиг хандлагыг харгалзан газрын тухай хууль тогтоомжид заасан хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газрын тэг гортигийг шинэчлэх асуудлыг судлан зохих арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн 15 сумын суурин газрын суурьшлын бүс буюу эдэлбэр газрын хил заагийг шинэчлэх саналыг 2023 оны 06 дугаар сард сумдын ИТХ-аар хэлэлцүүлнэ. Сумдын ИТХ-аас гарсан саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.	Урт хугацааны туршид хэрэгжинэ.

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хугацаа болоогүй 9 заалтын шалтгаан**

Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Шалтгаан
1	2020.07.01. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/	18.6.. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор батална.	Боловсруулан батлуулах хуулийн хугацаа болоогүй байна.
2	2023.01.01. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/	15.7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно.	журам 2023 оны 07 дугаар 01-ний өдөр батлагдан хэрэгжиж эхлэнэ.

3	2023.01.01. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/	Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно.	журам 2023 оны 07 дугаар 01-ний өдөр батлагдан хэрэгжиж эхлэнэ.
4	022 №72. МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ	1.10. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аймгийн байнгын оршин суугч иргэдэд орон нутгийн нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлтийг үзүүлэх.	хамааралгүй
5	2022_402. Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай	2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд “түр цэцэрлэг” байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	2023 оны эхний хагас жилийн байдлаар шинээр орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төсөл батлагдаагүй мөн архитектур төлөвлөлтийн даалгавар олгогдоогүй байна.
6	2023_63. Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай	3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. Хэрэгжилт	Технологит хугацаа 10-11 сард хийгдэнэ
7	2023_63. Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай	3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Технологит хугацаа 10-11 сард хийгдэнэ.
8	2021_19. 2021 оны 3 дугаар сарын 24-	II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж,	зөвлөх үйлчилгээний тендер зарласан.

	ний өдөр 19 дүгээр тэмдэглэл	хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	
9	2022_402. Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай	2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасгай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд “түр цэцэрлэг” байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	2023 оны эхний хагас жилийн байдлаар шинээр орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төсөл батлагдаагүй мөн архитектур төлөвлөлтийн даалгавар олгогдоогүй байна.

### ДӨРӨВ: ДҮГНЭЛТ

Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд Монгол улсын 4 хуулийн 15 заалт, УИХ-ын 2 тогтоолын 4 заалт, УИХ-ын байнгын хорооны 4 тогтоолын 12 заалт, Ерөнхийлөгчийн 5 зарлигын 11 заалт, Засгийн газрын 13 тогтоолын 20 заалт, ЗГ-ын хуралдааны 18 тэмдэглэлийн 19 заалт, ЗГ-ын 2 албан даалгаврын 4 заалт ҮАБЗ-ийн 3 зөвлөмжийн 5 заалт нийт 51 шийдвэрийн 90 заалтын хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 90.49 хувьтай байна. Хэрэгжилтийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.49 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүрэн хяналтад авах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор сар бүрийн эхний 10 хоногийг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах өдөр болгох талаар зөвлөмжийг өгч ажилласнаар үр дүн нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоолын хэрэгжилт 100 хувьтай буюу үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн заалт 82 хувийн хэрэгжилттэй буюу хамгийн бага хувьтай хэрэгжсэн нь удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалсан байгаа тул цаашид ажил эрчимжүүлэх шаардлагатай байгаад анхаарах хэрэгтэй.

Мөн Хэрэгжих шатандаа буюу эрчимжүүлэх шаардлагатай 19 заалт, удаашралтай буюу тасарч болзошгүй 3 заалт, хугацаа болоогүй буюу эрчимжүүлэх шаардлагатай 8 заалт нь удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө санхүү, хугацааны хувьд удаашралтай хэрэгжиж байгаад дүгнэлт хийн холбогдох хэлтэс агентлагийн дарга нар сүүлийн хагас жилийн төлөвлөлтөдөө тусган үр дүнг тооцох, ажил эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд шинээр гарсан шийдвэрийг цаг алдалгүй судлах ажлыг шат шатандаа хийх, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын болон хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, агентлагийн удирдлагуудыг судалгааны үр дүнд суурилсан мэдээллээр хангах нь зүйтэй гэж үзэж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад 7 шийдвэрийн 16 заалтыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд энэ чиглэлээр холбогдох агентлагуудад чиглэл өгөх шаардлагатай байна.

Цаашид үр дүнг жилийн эцсийн ажил дүгнэх үзүүлэлтэд тусгай шалгуур үзүүлэлт боловсруулан дүгнэх бөгөөд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр хэлтэс, агентлагууд онцгой анхаарч ажиллах шаардлагатай.

#### **ТАВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /**

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалт бүрийг хяналтандаа бүрэн авч удаашралтай байгаа заалтуудыг өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулах /бүх агентлаг/
2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа зохион байгуулсан ажлын үр дүнг бодитой, судалгаатай тоо баримтыг үндэслэн өмнөх үеийн мөн үетэй харьцуулж тайлагнаж байх /бүх агентлаг/
3. Бодлогын хэлтсүүд хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй, хугацаа болоогүй заалтуудыг холбогдох агентлагуудад хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах. /бодлогын хэлтэсүүд/
4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг агентлагийн дарга нар хянаж ирүүлэх /агентлагийн дарга нар/
5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлэхдээ нэг удаагийн шинжтэй, жил бүр тогтмол гардаг, хэрэгжилт тогтмолжсон заалтуудыг нэг бүрчлэн шүүн үзэж хяналтаас хасуулах хэсэгт тэмдэглэгээ хийж хэвших /бүх агентлаг/
6. Шинээр гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг сурталчлах, иргэдэд мэдээллэх ажлыг эрчимжүүлэх /бүх агентлаг/

7.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөрийг баталж гүйцэтгэлийн үр дүнг чанаржуулах /ГБХЗХГазар/

8.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайлагналт хангалтгүй төсвийг шийдвэрлүүлж захиран зарцуулсан үр дүнг бодитой гаргах /ГБХЗХГазар/

9. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар чиг үүргийг нарийвчлан гаргаж бодит ажилласан кейс үр дүнг нэгтгэн үнэлж дүгнэх, судалгаа нотолгоотой тоон баримтат үндэслэх./ГБХЗХГазар/

10.Аймаг, сумдуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх ажлын суурь судалгааг гаргаж хяналт тавьж үр дүнг нэмэгдүүлэх. /ГХБХБГазар/

11.Экологийн боловсролыг олгох соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх /БОАЖГазар/

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС